# ТАВДУГААР ХЭСЭГ. БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХАВСРАЛТ

1. Хавсралт №1. Соёлын өвийн үндэсний төвийн ажилтан, албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны 2025 оны тайлан

2. Хавсралт №2. Соёлын өвийн үндэсний төвийн ажилтан, албан хаагчдын 2025 оны сургалтын тайлан

3. Байгууллагын 2025 оны төсөв

Соёлын өвийн үндэсний төвийн
2025 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөний
1-р хавсралт

# СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН АЖИЛТАН, АЛБАН ХААГЧДЫН АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААНЫ 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН

| Д/д | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэл-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, журмын хүрээнд шаардлагатай дүрэм, журмыг шинэчлэх, боловсронгуй болгох. | Байгууллагын төсөв | - Шинээр болон шинэчлэн баталсан журмын тоо. | 2 журам шинэчилсэн.<br>3 журам шинээр боловсруулсан. | Эхний хагас жилд:<br>Шаардлагатай дүрэм, журмыг шинэчилнэ.<br>Жилийн эцэст:<br>Шаардлагатай дүрэм, журмыг шинэчилнэ. | - Үндэсний төвийн хөдөлмөрийн дотоод журамд нэмэлт өөрчлөлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн А/02 дугаар тушаалаар байгуулж, 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн А/11 дүгээр тушаалаар хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн баталсан. Хамт олны хурлаар ажилтан, албан хаагчдад хөдөлмөрийн дотоод журамд оруулсан нэмэлт өөрлөлтийг танилцуулсан.<br>- Захиргааны зөвлөлийн бүрэлдэхүүн, зөвлөлийн ажиллах журмыг 2025 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн А/12 дугаар тушаалаар шинэчлэн баталсан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2. | Ажлын байрны сэтгэл ханамжийн судалгаа авах, судалгааны үр дүнгээр холбогдох арга хэмжээг хэрэгжүүлэх, | Байгууллагын төсөв | - Судалгаанд хамрагдсан ажилчдын тоо.<br>- Судалгааны хувь. | Анх удаа | Эхний хагас жилд:<br>Судалгаа боловсруулна.<br>Жилийн эцэст:<br>Судалгааг авч, гарсан үр дүнд дүн шинжилгээ хийж холбогдох арга хэмжээг хэрэгжүүлнэ. | - Ажилтны сэтгэл ханамжийн судалгааг 15 асуулт, 2 санал (бичих) бүхий асуумжийг боловсруулан 2025 оны 05 дугаар 07-ны өдөр нийт ажилтан, албан хаагчдаас бичгээр авсан. Судалгаанд 47 албан хаагч буюу нийт албан хаагчдын 94% оролцсон.<br>Судалгааны үр дүнд албан хаагчдын 40-55% нь сэтгэл ханамж дундуур гэсэн асуулгад дүн шинжилгээ хийж дараах арга хэмжээг хэрэгжүүллээ. Үүнд:<br>- Шаардлагатай техник, хэрэгслийн жагсаалтыг гаргаж ССАЖЯ-ны Санхүү, хөрөнгө оруулалтын газарт 2025 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 01/291 дугаар албан бичгээр 3 багцын 1,154,307,198 төгрөгийн тоног төхөөрөмжийн төсвийн саналыг хүргүүлсэн.<br>- Ажилтны харилцаа хандлагын асуулгад 54% нь сэтгэл дундуур, хангалтгүй гэсэн асуулгын дүнд Монгол Улсын Ёс зүйн хорооноос “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай ойлголт” сургалтыг ажилтан, албан хаагчдад зориулж 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр зохион байгууллаа. | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Байгууллагаас үзүүлж буй дэмжлэг туслалцаанд ажилтны сэтгэл дундуур байгаа нь хөдөлмөрийн дотоод журмын заалт, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсөв байхгүй, жил бүрийн байгууллагын төсөвт тусгадаг боловч нийгмийн баталгаанд зарцуулах зардалгүй тул мөнгөн болон бусад зүйлийн дэмжлэг тусламж үзүүлэх боломж дутмаг байна. | |
| 3. | Албан хаагчийг мэргэжил боловсрол, ур чадвараа дээшлүүлж магистрантур, докторантурт суралцах нөхцөл боломжоор хангах. | Байгууллагын төсөв | - Ажилчдын тоо. | Магистрт -11,<br>Докторантурт -3 | Эхний хагас жилд:<br>Суралцах нөхцөл боломжоор хангаж ажиллана.<br>Жилийн эцэст:<br>Суралцах нөхцөл боломжоор хангаж ажиллана. | - 2025 оны жилийн эцсийн байдлаар Удирдлагын академи, СУИС, МУИС-ийн магистрантурт 6, МУИС, СУИС-ийн докторантурт 4, нийт 10 албан хаагч суралцаж байна. 1 ажилтан магистрын зэргээ хамгаалсан.<br>- Байгууллагын хүний нөөцийн чадамжийг сайжруулах, ажлын байранд хөгжих боломжоор хангаж, магистр, докторт суралцаж байгаа албан хаагчдад цалинтай чөлөөг олгож, ажлын цагийн хуваарийг зохицуулан ажилласан. | 100% |
| 4. | Ажлын гүйцэтгэл, үр дүнг харгалзан шагналын шалгуур болзлыг хангасан албан | Байгууллагын төсөв | - Яамны, Засгийн газрын, төрийн дээд цол, одон медалиар | Алтан гадас одон 3, Хөдөлмөрийн хүндэт медаль 3, Соёлын тэргүүний ажилтан хүндэт | Эхний хагас жилд:<br>Шагналд тодорхойлох албан хаагчдын | - Ажил үүргээ тогтмол сайн гүйцэтгэж шагналын болзол хангасан ажилтнуудыг Төрийн дээд шагнал Хөдөлмөрийн хүндэт | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хаагчдыг яамны “Жуух бичиг”, салбарын Тэргүүний ажилтан, төрийн дээд шагналд тодорхойлох. | | шагнуулсан албан хаагчид | тэмдэг 1, яамны жуух бичгээр 1 ажилтан шагнагдсан. | мэдээллийг гаргах, холбогдох газарт уламжлана.<br>Жилийн эцэст:<br>Шагналыг холбогдох газарт уламжлана. | медаль, Засгийн газрын болон яамны шагналаар шагнуулахаар нэр дэвшүүлэн Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яаманд 2025 оны 01/322, 01/350 дугаар албан бичгээр тодорхойлон хүргүүлснээс Хөдөлмөрийн хүндэт медалиар 3, Соёлын тэргүүний ажилтан тэмдгээр 1, яамны Жуух бичгээр 5 албан хаагч шагнууллаа. | |
| 5. | Албан хаагчдын орон сууцны нөхцөл байдлын судалгаа, гаргаж, тэдний эрэлт хэрэгцээнд үндэслэн хүсэлтийг холбогдох газарт уламжлах. | Байгууллагын төсөв | - Судалгааны тоон мэдээ<br>- Хүсэлтийн тоо. | 3 албан хаагч түрээсийн орон сууцанд амьдардаг. | Эхний хагас жилд:<br>Орон сууцны судалгаа гаргана.<br>Жилийн эцэст:<br>Хүсэлтийг холбогдох газарт уламжилна. | - Хүний нөөцийн судалгаа, нийгмийн баталгаа хангах хөтөлбөр боловсруулах ажлын хүрээнд 51 албан хаагчдын орон сууцны судалгааг гаргасан.<br>- Судалгаагаар төрийн байгууллагаас орон сууцны дэмжлэг авсан албан хаагч байхгүй, хашаа байшинд 9, гэрт амьдардаг 3, хашаа байшинд гэр түрээсэлдэг 1, орон сууцанд байр түрээсэлдэг 5, хашаа байшин түрээсэлдэг 1 албан хаагч байна.<br>- “ТОСК” ТӨХХК-д “Солонго 1, 2 орон сууцны хороолол”-д байгууллагын албан хаагчдын орон сууц, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлж, орон сууцны квотод хамруулж өгөхийг хүсэж 2025 оны 09 дүгээр сарын | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 19-ний 01/533 дугаар албан бичиг хүргүүлсэн. | |
| 6. | Албан хаагчдад ур чадварын, улирлын мөнгөн урамшууллыг тухайн албан хаагчийн ажлын гүйцэтгэлтэй уялдуулан олгох. | Байгууллагын төсөв | - Ур чадварын, улирлын мөнгөн урамшуулалд хамрагдсан албан хаагчид, зарцуулсан мөнгөн дүн. | -50 албан хаагчдад 131,902,788.93 төгрөгийн ур чадвар, 45,436,350 төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон. | Эхний хагас жилд:<br>Холбогдох журмын дагуу ур чадварын, улирлын мөнгөн урамшууллыг олгоно.<br>Жилийн эцэст:<br>Холбогдох журмын дагуу ур чадварын, улирлын мөнгөн урамшууллыг олгоно. | - Үндэсний төвийн захирлын 2025 оны Б/02, Б/17, Б/41, Б/61 дүгээр тушаалаар албан хаагчдад 1, 2, 3, 4 дүгээр улирлын ур чадварын нэмэгдлийг, Б/13, Б/37, Б/57 дугаар тушаалаар 1, 2, 3 дугаар улирлын ажлын үр дүнгийн урамшууллыг тогтоож олгосон.<br>- 2025 оны 11 дүгээр сарын байдлаар 54 албан хаагчдад 160,564,407.49 төгрөгийн ур чадвар, 103,374,450 төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон. | 100% |
| 7. | Албан хаагчдын ажилдаа ирэх, буцах нийтийн тээврийн унааны зардал, өдрийн хоолны мөнгийг олгох. | Байгууллагын төсөв | - Хоол, унааны хөнгөлөлтөд зарцуулсан мөнгөн дүн. | -50 албан хаагчдад хоолны унааны зардалд 136,966,000 төгрөг зарцуулсан. | Эхний хагас жилд:<br>Тухайн жилийн төсөвт багтаан олгоно.<br>Жилийн эцэст:<br>Тухайн жилийн төсөвт багтаан олгоно. | - Захирлын 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн “Цалин хөлс нэмэгдлийг шинэчлэн батлах тухай” А/01 дүгээр тушаалын 4 дүгээр хавсралтаар 2025 оны цалингийн төсөвт багтаан шинэчлэн тогтоосноор албан хаагчдын нийтийн тээврийн унааны зардлийг өдрийн 2000, өдрийн хоолны мөнгийг 20,000 төгрөгөөр тооцон олгож байна.<br>- 2025 оны 11 сарын байдлаар дунджаар 54 албан хаагчдад хоол, унааны зардалд нийт 224,930,000 төгрөг зарцуулсан. Үүнээс хоолны зардалд 205,700,000, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | унааны зардалд 19,230,000 төгрөг. | |
| 8. | Албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулж урсгал засвар хийх, албан хэрэгцээнд зориулж хувцас хэрэглэл, тоног төхөөрөмжөөр хангах. | Байгууллагын төсөв | - Бараа материалын тоо.<br>- Тоног төхөөрөмжийн тоо. | 2024 онд ажилтнуудыг аюулгүй байдлын хэрэглэлээр цаг тухайд нь хանган ажилласан. | Эхний хагас жилд:<br>Ажлын байр, өрөөнд тохижилт, засвар үйлчилгээг хийж, тухай бүр хэрэгцээт хэрэглэгдэхүүнээр хангаж ажиллана.<br>Жилийн эцэст:<br>Тухай бүр хэрэгцээт хэрэглэгдэхүүнээр хангаж ажиллана. | - Үзмэр, эд өлгийн зүйлс, олдворын сэргээн засварлалтад ашиглах химийн бодис, цавуу зэрэг хор аюултай уусмалыг найруулахад аюулгүй ажиллагааг хангаж лабораториудын сорох шүүгээний 7 агааржуулалтын хоолойг гадагш байрлуулж сорогч шүүгээг ажиллагаанд оруулсан. Мөн уран зураг, археологийн олдвор сэргээн засварлах лабораторид шинээр 2 агааржуулах хоолой суурилуулж ашиглалтад оруулсан.<br>- Ажлын 6 өрөөнд цахилгааны монтаж хийсэн.<br>- Байгууллагын барилгын ашиглалтын нөхцөлийг сайжруулж аваарын 4 гарц, үүдний шилэн фасад, 1 давхрын хана болон чулууны заалны ханыг эмульсдэх зэрэг урсгал завсар хийж, барилгыг тойрсон замын гэрэлтүүлгийг шинээр сольж хэвийн ажиллагаатай болгосон.<br>- ССАЖЯ-аас Dell брендийн 24 инчийн дэлгэцтэй I7 4 ширхэг нийт 12,480,000 төгрөгийн иж бүрэн суурин компьютер, HP laser jet pro M102a маркын 3 ширхэг нийт | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 904,200 төгрөгийн принтер (хэвлэгч) ирсэн бөгөөд шаардлагатай албан хаагчдын ажлын хэрэгцээнд зориулан олголоо. | |
| 9. | Ажилтан, албан хаагчдад буцалтгүй тусламж, дэмжлэгийг Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу шийдвэрлэх. | Байгууллагын төсөв | -Буцалтгүй тусламж үзүүлсэн албан хаагчийн тоо, мөнгөн дүн | Нэг удаагийн буцалтгүй тусламжийг 9 ажилтанд,<br><br>8 хүртэл насны хүүхэдтэй ажилтнуудын өглөө ирэх, орой тарах цагийг 1 цагаар богиносгон тооцож ажлын цагийг зохицуулан ажиллуулж байна. | Эхний хагас жилд:<br><br>Захирлын тушаалаар олгоно.<br><br>Жилийн эцэст:<br><br>Захирлын тушаалаар олгоно. | - Авран хамгаалах, эрсдэлийн судалгааны газрын Шинжээч А.Цэнд-Аюушийн шинээр төрсөн хүүхдэд 500,000 төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж, сар шинийн баяраар ахмадуудад хүндэтгэл үзүүлж, гарын бэлэг хүргүүлж, 11 ахмадад нийт 550,000 төгрөгийг олгосон.<br><br>- Өндөр насны тэтгэвэр тогтоолгох эрх үүсэж, төрийн алба хаасан хугацааны нэг удаагийн буцалтгүй тусламжийг 4 ажилтанд олгосон.<br><br>- Захирлын 2025 оны 10 дугаар сарын 01-ний Б/59 тушаалаар хүүхэд хамгааллыг хэрэгжүүлэх зорилгоор 2-8 хүртэл насны хүүхэдтэй ажилтнуудын өглөө ирэх, орой тарах цагийг 1 цагаар богиносгон тооцож ажлын цагийг зохицуулан ажиллуулж байна. | 100% |
| 10. | Хамт олны идэвхтэй амралт, аялал, урлаг, спортын арга | Байгууллагын төсөв | -Зохион байгуулсан уралдаан тэмцээний тоо | 2024 онд 2 уралдаан тэмцээн зохион байгуулсан. | Эхний хагас жилд: | - Байгууллагын ажилтнуудын ажиллах урам зориг, эрмэлзлэлийг бий болгох, хүнийг хөдөлгөөний | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэмжээ, ажил мэргэжлийн уралдааныг жилд 2-оос доошгүй удаа зохион байгуулах, шагнаж урамшуулах, | | - Оролцсон хүний тоо | | 1 спортын арга хэмжээг зохион байгуулна.<br><br>Жилийн эцэст:<br><br>1 олон нийтийг хамарсан арга хэмжээг зохион байгуулна. | тусламжтайгаар эрүүлжүүлэх зорилгоор 2025 оны 01 дүгээр сарын 31-нд тус Үндэсний төвийн нярав Б.Отгонцэцэг өөрийн нэрэмжит волейболын тэмцээнийг зохион байгуулж, байгууллагын 51 албан хаагч оролцсон.<br><br>- 2025 оны 04 дүгээр сарын 04-нд “Байгууллагын 2025 оны аварга шалгаруулах” волейболын тэмцээн зохион байгуулж, үндэсний төвийн бүх ажилтан, албан хаагч оролцсон.<br><br>- Соёл, урлагийн ажилтны өдрийг угтан соёлын байгууллагуудын дунд 2025 оны 09 дүгээр сарын 09-12-ны хооронд зохион байгуулагдсан спортын таван төрөл сагсан бөмбөг, волейбол, үндэсний бөх, үндэсний шагайн харваа, олс таталтын тэмцээнд байгууллагын ажилтан, албан хаагчид идэвхтэй оролцож, эрэгтэй волейболын төрөлд мөнгөн медаль хүртэж, эмэгтэй тамирчид 4 дүгээр байранд шалгарсан. | |
| 11. | Жендэрийн мэдрэмжтэй ажлын байрыг дэмжиж хүйсийн тэнцвэрт болон ажил эрхлэлтийн байдал, дундаж | Байгууллагын төсөв | - Ажилчдын тоо. | “Хүний эрхийн ойлголт” сэдвээр нийт албан хаагчдад сургалт зохион байгуулсан. | Эхний хагас жил:<br><br>1 сургалт, мэдээллийн арга хэмжээ зохион байгуулна. | - Жендэрийн Үндэсний Хорооны ажлын албаны Эрэгтэйчүүдийн хөгжлийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн Д.Батхишиг 2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр “Монгол | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | наслалт, ажлын байран дахь харилцаа хандлагын талаар сургалт, мэдээлэлд албан хаагчдыг хамруулах | | | Хөдөлмөрийн харилцаанд жендэрийн эрх тэгш байдлыг хангасан. | Жилийн эцэст:<br><br>Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллана. | эрэгтэйчүүдийн амьдралын чанар ба анхаарах асуудлууд" сургалт, ХУД-ын 21 дүгээр хорооны "Дуут жинст" өрхийн эрүүл мэндийн төвийн нийгмийн ажилтан, хүний их эмч н.Бүтэд "Эрүүл амьдралын дадал хэвшилд суралцах нь" сэдвээр, Иргэдийн хэрэглээний боловсролын төвөөс сургагч багш, хүнсний аюулгүй байдал судлалын докторант Б.Марал "Амьдралын эрүүл дадал зуршил, харилцаа хандлага" сэдвээр сургалтыг 2025 оны 10 дугаар сарын 02-ны өдөр тус тус зохион байгууллаа. Сургалтад албан хаагчид 60-80%-ийн ирцтэй хамрагдлаа.<br><br>Байгууллагын жендэрийн харьцаа:<br><br>- Нийт албан хаагчдын 25 буюу 46%-ийг эмэгтэйчүүд, 29 буюу 54%-ийг эрэгтэйчүүд,<br><br>- Удирдах албан тушаалтан 10 хүнээс эрэгтэй 8 буюу 80%, эмэгтэй 2 буюу 20%-ийг эзэлж байна.<br><br>- Ажлын байрны сул орон тоог нийтэд нээлттэй зарлахдаа хүйсийн талаар дурдаагүй, аль нэг хүйсийг давуу гэж үзсэн агуулга тусгаагүй бөгөөд хувь хүний мэдлэг, боловсрол, мэргэжил, мэргэшил, ур чадвар, туршлагад | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тулгуурлан сонгохдоо хүйсийн тэнцвэртэй байдлыг харгалздаг. | |
| 12. | Ажлын байрны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартыг хангуулах ажлыг зохион байгуулах, | Байгууллагын төсөв | -Сургалт, арга хэмжээний тоо | Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, эрүүл мэндийг хамгаалах зорилгоор сургалт 2 зохион байгуулж, 1 журам, 1 дүрэм батлуулсан.“Химийн бодистой ажиллах аюулгүй ажиллагааны журам”-ыг батлуулсан. | Эхний хагас жилд:<br>1 сургалт, арга хэмжээг зохион байгуулна.<br>Жилийн эцэст:<br>Стандартыг хангуулах 1 арга хэмжээг зохион байгуулна. | - ХАБЭА зөвлөлийн 2025 оны ажлын төлөвлөгөөг батлуулсан. Соёлын өвийн үндэсний төвийн 16 сэргээн засварлагчид 2025 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр “Химийн бодис хэрэглэгдэхүүнтэй харьцах аюулгүй ажиллагаа” сэдвийн хүрээнд сургалт зохион байгуулсан.<br>- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартыг хангуулах ажлын хүрээнд байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дотоод журмын дагуу албан томилолтоор ажиллах үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгааг 2 удаа 9 албан хаагчид, “Нүүдэлчин” соёлын фестивальд ажилласан 27 албан хаагчдад Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн санамжийг танилцуулж ажиллалаа. | 100% |

---**---

Соёлын өвийн үндэсний төвийн
2025 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөний
2 дугаар хавсралт

СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН АЖИЛТАН,
АЛБАН ХААГЧДЫН 2025 ОНЫ СУРГАЛТЫН ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

| Д/д | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэл-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | "Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай" хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж, ёс зүйн алдаа, зөрчил гаргах, зөрчил үйлдлээс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, ажлын байрны дарамт, ялгаварлан гадуурхалтаас сэргийлэх сургалт зохион байгуулах. | Байгууллагын төсөв 500,000 | - Сургалтын тоо.<br>- Хамрагдсан ажилтан, албан хаагчдын тоо. | 2 сургалт зохион байгуулсан. | Эхний хагас жилд:<br>1 сургалт зохион байгуулна.<br>Жилийн эцэст:<br>1 сургалт зохион байгуулна. | - Байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороог 2025 оны 02 дугаар сарын 26-ны А/09 дугаар тушаалаар шинэчлэн байгуулж, Захиргаа, удирдлагын газартай хамтран ажилтан, албан хаагчдад "Манлайлагч гэж хэн бэ" сэдэвт сургалтыг 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдөр зохион байгуулж, 41 албан хаагч хамрагдсан.<br>Монгол Улсын Ёс зүйн хорооноос ажилтан, албан хаагчдад зориулж 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр "Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомж", "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам, ёс зүйн зөрчил бүртгэл хяналтын дэд систем" сэдэвт сургалт зохион байгууллаа. Энэхүү сургалтыг Монгол Улсын Ёс зүй хорооны Соён гэгээрүүлэх хэлтсийн дарга Ц.Заяхүү, Дэд хороо хариуцсан ахлах мэргэжилтэн Д.Мөнхжин нар удирдаж, сургалтад оролцогчдын сонирхсон | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | асуултад хариулж, нэмэлт мэдээлэл өглөө. Сургалтад 32 албан хаагч оролцлоо. | |
| 2. | БНШК-ын үйл ажиллагаа, төрийн архивт баримт шилжүүлэх арга зүй, Архивын хадгалалт, данс, бүртгэл үйлдэх арга зүйн талаар сургалт зохион байгуулах. | Байгууллагын төсөв 500,000 | - Сургалтын тоо.<br>- Хамрагдсан ажилтан, албан хаагчдын тоо. | 2 албан хаагч Архивын ерөнхий газраас зохион байгуулсан сургалтад хамрагдсан. | Эхний хагас жилд:<br>Мэргэжлийн байгууллагатай хамтран нийт албан хаагчдад 1 сургалт зохион байгуулна.<br>Жилийн эцэст:<br>- | - Архивын ерөнхий газарт байгууллагын албан хаагчдад архив, албан хэрэг хөтлөлтөөр сургалт авах тухай 2025 оны 03 дугаар сарын 10-ны 01/156 дугаар албан бичгээр хүсэлт гаргасны дагуу АЕГ-ын газрын Үндэсний төв архивтай хамтран 2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр “Архив, албан хэрэг хөтлөлт”-ийн сургалтыг 3 чиглэлээр зохион байгууллаа. Эхний сургалтыг ҮТА-ын Мэргэжил, арга зүй удирдлагын газрын ахлах мэргэжилтэн Ц.Золжаргал “Баримт бичгийг стандартын дагуу зохион бүрдүүлэх арга зүй” сэдвээр хийж 27 ажилтан, хоёр дахь сургалтыг ҮТА-ын ахлах мэргэжилтэн С.Пүрэвсүрэн “Шийдвэрлэгдсэн баримтаар хадгаламжийн нэгж бүрдүүлэх, байгууллагын архивд баримт хүлээлгэн өгөх арга зүй” сэдвээр хийж 12 ажилтан, гурав дахь сургалтыг ҮТА-ын КГЗДАБА-ын кино, дүрс бичлэгийн инженер Д.Бат-Үндрах “Кино, гэрэл зураг дуу авианы баримтыг эмхлэн цэгцлэх хадгаламжийн нэгж бүрдүүлэх данс бүртгэл үйлдэх арга зүй” сэдвээр хийж 19 ажилтан албан хаагчид хамрагдлаа. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3. | Хүний эрх, жендэрийн эрх тэгш байдлыг хангаж, холбогдох байгууллагатай хамтран сургалт зохион байгуулах. | Байгууллагын төсөв<br>500,000 | - Зохион байгуулсан сургалтын тоо.<br>- Зохион байгуулсан арга хэмжээний тоо. | 1 сургалт зохион байгуулсан. | Эхний хагас жилд:<br>1 сургалт зохион байгуулна.<br>Жилийн эцэст:<br>1 арга хэмжээ зохион байгуулна. | Монгол Улсын Ерөнхий сайдын 2024 оны 71 дүгээр захирамжаар батлагдсан “Эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүг багасгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г хэрэгжүүлэх ажлын хүрээнд 4 сургалтыг зохион байгууллаа.<br>- 2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр Жендэрийн Үндэсний Хорооны ажлын албаны Эрэгтэйчүүдийн хөгжлийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн Д.Батхишиг “Монгол эрэгтэйчүүдийн амьдралын чанар ба анхаарах асуудлууд” сургалт,<br>- 2025 оны 05 дугаар сарын 27-ны өдөр ХУД-ын 21 дүгээр хорооны “Дуут жинст” өрхийн эрүүл мэндийн төвийн нийгмийн ажилтан, хүний их эмч Р.Бүтэд “Эрүүл амьдралын дадал хэвшилд суралцах нь” сэдвээр,<br>- 2025 оны 08 дугаар сарын 27-ны өдөр “Ажлын байрны стрессээс хэрхэн ангид байх вэ?“ сэдэвт сургалт,<br>- 2025 оны 10 дугаар сарын 02-ны өдөр Иргэдийн хэрэглээний боловсролын төвөөс сургагч багш, хүнсний аюулгүй байдал судлалын докторант Б.Марал “Амьдралын эрүүл дадал зуршил, харилцаа хандлага” сэдвээр сургалтыг тус тус зохион байгууллаа. Сургалтад албан хаагчид 60-80%-ийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ирцтэйгээр хамрагдлаа. Сургалтад байгууллагын нийт албан хаагчид идэвхтэй хамрагдаж, тэдэнд эрүүл амьдралын дадал хэвшил, ойлголт, ухамсарыг дээшлүүлж, эрүүл мэнд, амьдралын дадал хэвшилдээ хариуцлагатай хандаж хандлагаа өөрчилж өдөр тутмын үйл ажиллагаандаа хэвшүүлэхийг зөвлөж, мэдлэг, мэдээллийг олголоо. | |
| 4. | “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай”, “Гамшгаас хамгаалах тухай” хуулийн танилцуулга, сургалт зохион байгуулах. | Байгууллагын төсөв<br>500,000 | - Зохион байгуулсан сургалтын тоо.<br>- Хамрагдсан ажилтан, албан хаагчдын тоо. | 2 сургалт зохион байгуулсан. | Эхний хагас жилд:<br>Ажлын байрны аюулгүй ажиллагааны дүрэм журмыг мөрдөх тухай 1 сургалт зохион байгуулна.<br>Жилийн эцэст:<br>Мэргэжлийн байгууллагатай хамтран 1 сургалт зохион байгуулна. | Соёлын өвийн үндэсний төвийн 16 сэргээн засварлагчид 2025 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр “Химийн бодис хэрэглэгдэхүүнтэй харьцах аюулгүй ажиллагаа” сэдвийн хүрээнд сургалт зохион байгуулсан.<br>ХУД-ийн Онцгой байдлын хэлтсийн Гал түймэр унтраах, аврах 30 дугаар ангитай хамтран "Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх эрсдэлийг бууруулах" сэдвээр 2025 оны 10 дугаар сарын 21-ний өдөр нийт албан хаагчдад сургалт зохион байгууллаа. Сургалтаар Галын аюулгүй байдлын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.4 дэх “Ажилтан, алба хаагчийг гал түймрээс урьдчилан сэргийлэх, авран хамгаалах, гал түймэр унтраах арга ажиллагаанд сургах, мэдлэгийг нь дээшлүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх” заалтыг | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тайлбарлан таниулах, сурталчилж, галын аюулаас сэргийлэх мэдлэгийг олголоо. | |
| 5. | Авлигын эсрэг хууль, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд сургалт зохион байгуулах. | Байгууллагын төсөв 500,000 | - Зохион байгуулсан сургалтын тоо.<br>- Хамрагдсан ажилтан, албан хаагчдын тоо. | Анх удаа | Эхний хагас жилд:<br>1 сургалт зохион байгуулна.<br>Жилийн эцэст:<br>1 сургалт зохион байгуулна. | Авлигатай тэмцэх газраас 2025 оны 05 дугаар сарын 13-нд Эрх бүхий албан тушаалтнуудад зориулан зохион байгуулсан цахим сургалтад хамрагдсан.<br>"Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь" сэдвээр Авлигатай тэмцэх газрын Урьдчилан, сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн ажилтан, комиссар С.Янжинлхам 2025 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 10.00 цагт цахимаар сургалт хийлээ. Сургалтад 32 албан хаагч оролцлоо. | 90% |
| 6. | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай сургалт зохион байгуулах. | Байгууллагын төсөв 500,000 | - Зохион байгуулсан сургалтын тоо.<br>- Хамрагдсан ажилтан, албан хаагчдын тоо. | Анх удаа | Эхний хагас жилд:<br>1 сургалт зохион байгуулна.<br>Жилийн эцэст:<br>1 сургалт зохион байгуулна. | Байгууллагын албан хаагчдад гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт авах хүсэлтийг Хан-Уул дүүргийн Цагдаагийн хоёрдугаар хэлтэст 2025 оны 05 дугаар сарын 28-ны 01/324 дугаар албан бичгээр хүргүүлсэн.<br>Цагдаагийн ерөнхий газрын Хар тамхитай тэмцэх албатай хамтран “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор уршиг, хэрэглэсэн хүнд илрэх шинж тэмдэг, таних арга, хууль эрх зүйн хариуцлага” сэдэвт сургалтыг 2025 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр зохион байгуулж ХТТА-ны ахлах мэргэжилтэн, Цагдаагийн ахлах дэслэгч М.Даваасамбуу | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | удирдаж, хар тамхины хор хөнөөлийн талаар мэдлэг мэдээлэл олгосон бөгөөд байгууллагын 36 албан хаагч оролцлоо. | |

---***---